

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -10
Шөнө -22

УЛС ТӨР

Д.ХАЯНХЯРВАА: СОНГУУЛИЙН ДАРАА ТӨРИЙН АЛБА ТОГТВОРГУЙ БОЛЖ БАЙНА

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ТАХАРЫН АЛБА БАЙСАН БОЛ...

V нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Ашгүй, НӨАТ-ыг зах руу чиглүүлэх нь

ЮУ ҮЗҮҮЛЭХЭЭ Ч МЭДДЭГГҮЙ

Н.ПУНЦАГ

НӨАТ-ын хууль гаргаж, иргэд баримтаа бүртгүүлэн сугалаанд оролцож, хоёр хувийн буцаалтаа эргүүлж авна гэж ярьж байхад харлуулж ярьж байсан хүн дөөнгүй бий. Тэр дундаа улстөрчид. Гэтэл өнгөрсөн 2016 оны тоо баримт энэ хууль ямар үр дүнтэй, хэрэгтэй байсныг гэрчилнэ. Тухайлбал, өнгөрсөн онд татварын төлөвлөгөө давж биелсэн. Өмнө нь НӨАТ хэзээ ч төлөвлөгөөндөө хүрч биелж байгаагүй юм билээ. Харин 2016 онд 100 хувь давж биелсэн. Улсын төсөвт татвараас нэг их наяд 560 тэрбум төгрөг орсны 35 хувь буюу 555 нь НӨАТ-аас орсон мөнгө байх жишээтэй. Дээрээс нь өнгөрсөн онд НӨАТ төлөгчөөр 2708 аж ахуйн нэгж бүртгүүлсэн байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.ПУНЦАГБОЛД

Монголын эдийн засаг тэр чигээрээ уул уурхай дээр л тогтож байгаа. Уул уурхай зогсонги байдалд ороод, дэлхийн зах зээлд дээрнүүрс, зэс, бусад байгалийн баялгийн үнэ жаахан буурчихаар л Монгол Улсын эдийн засаг элгээрээ мөлхдөг. Уг нь Монгол хөдөө аж ахуйн орон. Нэг хүнд ногдох газар нутгийнхаа тоогоор дэлхийд тэргүүлдэг, 60 сая малтай. Газар тариалан, хөдөө аж ахуйг тултал нь хөгжүүлж болохоор. Гэвч бид зүгээр л газар доорхи баялгаа хараад л гар хумхин суусаар өдийг хүрсэн. Сүүлийн жилүүдэд эдийн засгаа солонгоруулах талаар ярьж эхэлсэн. Харамсалтай нь одоохондоо нэг их солонгороод, алаглаад байгаа юм алга. Уул уурхайгаас хараат хэвээр, эдийн засаг элгээрээ хэвтсээр л.

Үргэлжлэл нь III нүүрт

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Академик боловсролыг эрхэмлэгч АШУҮИС-ийнхан



Н.БАТЗАЯА

Монгол Улсын анагаахын боловсролын салбарт томоохон ажлыг өрнүүлэн, анагаахын боловсролын салбарын зүг чиг болон яваа байгууллага бол Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль билээ. Тэгвэл бид тус сургуулийн үйл ажиллагаа, бодлого чиглэлийн талаар дэд захирлуудтай нь цөөн хором ярилцлаа.

Н.Сүмбэрзул: Бид сургалтын хөтөлбөрөө шинэчилж, дэлхийн анагаах ухааны сургалттай хөл нийлүүлэн алхана

/АШУҮИС-ийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал/

-Сүүлийн үед танай сургуульд томоохон бүтээн байгуулалтын ажлууд нэлээд өрнөж буй.

Үргэлжлэл нь VII нүүрт

ДЭЛХИЙ

АНУ-ЫН ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ГЭР БҮЛТЭЙ ТАНИЛЦ

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп тангаргаа өргөж, албан ёсоор Цагаан ордонд нүүж ирсэн билээ. Тэгвэл энэ удаа шинэхэн Ерөнхийлөгчийн гэр бүлийг уншигчиддаа танилцуулж байна.

АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч 70 настай Доналд Трамп гурван удаа гэрлэсэн нэгэн. Анхны эхнэр Иванагаас нь Ивана, Доналд, Эрик нарын нэг охин, хоёр хүү төрсөн бол удаах эхнэр Марла Маплес Таффани гэх нэг охин төрүүлж өгсөн байдаг. Харин одоогийн эхнэр Мелани нэг хүү төрүүлсэн бөгөөд Баррон эдүгээ 10 настай юм. Д.Трампын хүүхдүүд олны анхаарлын төвд

өссөний зэрэгцээ гурван том хүүхэд нь аль хэдийнэ аз жаргалаа олж, амжилттай явж буй. Харин эдүгээ 23 настай Тиффани Трамп саяхан Пеннсилванийн их сургуулийг төгссөн. Сошиал сүлжээний идэвхитэй хэрэглэгч гэрбээр инстаграмд тун ч алдартай гэнэ. Баррон Трампын хувьд өөрийн цамхагтаа өдрийг өнгөрүүлээд завгүй.

Үргэлжлэл нь VI нүүрт

19 ДЭХ ЖИЛЭЭ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины I улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **19800**

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк	Хугалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2482.00	2499.00	ФУНТ	3028.00
ЕВРО	2634.00	2707.00	РУБЛЬ	40.00
ИЕН	21.61	22.00	ЮАНЬ	360.30
			АМ.ДОЛЛАР	2483.00
			ЕВРО	2636.00
			ИЕН	21.59
			Зарах	2499.00
			ФУНТ	3044.00
			РУБЛЬ	40.39
			ЮАНЬ	360.00
			Зарах	2705.00
			ФУНТ	3122.00
			РУБЛЬ	43.76
			ЮАНЬ	365.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ХААЛТАЙ ХУРАЛДААН

Д.ХАЯНХЯРВАА: СОНГУУЛИЙН ДАРАА ТӨРИЙН АЛБА ТОГТВОРГҮЙ БОЛЖ БАЙНА

Ж.ОТГОН

УИХ дахь МАН-ын бүлэг хуралдаж, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцсэн байна. Дараа нь бүлгийн хурлаар хэлэлцсэн асуудлаар УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Д.Тогтохсүрэн болон бүлгийн дарга Д.Хаянхярваа нар мэдээлэл хийлээ.

Хуралдаанаар Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өргөн барьсан Төрийн албаны тухай хууль мөн нэр бүхий гишүүдийн боловсруулсан хуулийн талаар хэлэлцжээ. Энэ талаар бүлгийн дарга Д.Хаянхярваа “МАН-ын бүлэг улс төрийн бусад намууд болон Төрийн албаны зөвлөлтэй ярьж байж Төрийн албаны тухай хуулийг чамбайруулж гаргах ёстой гэдэгт санал нэгдсэн. Зургаа, долоон удаагийн сонгуулийн үр дүнг харж байхад сонгуулийн дараа төрийн алба тогтворгүй болж байна гэдэгтэй хүн бүхэн санал нийлдэг. Тиймээс төрийн албыг тогтвор суурьшилтай байлгахын тулд Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх шаардлагатай байна” гэлээ. Мөн уг хуулийг хэрхэн шинэчлэх, санал дүгнэлтийг бүлгийн гишүүдээсээ авсан хэмээгээд ойрын үед УИХ-д өргөн барих гэнэ. Харин Төрийн албаны тухай хуулийг санаачлагчдын нэг УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн “Бид сонгуульд орохдоо төрийн албыг дархлаатай болгоно гэсэн зорилт тавьсан. Саяхан батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт мөн төрийн албыг



тогтвортой болгох чиглэлээр тодорхой гурван заалт орсон. Үүнтэй холбогдуулан УИХ-ын гишүүдээс төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад бүлгийн хурлаар хэлэлцүүлж саналав. Одоо мөрдөгдөж байгаа хууль маань долоон бүлэг 41 зүйлтэй. Шинээр боловсруулсан хууль 33 бүлэг 109 зүйлтэй том хууль болж байна. Нэгдүгээрт, энэ хуулиар төрийн албыг улс төрөөс аль болох хамаарал багатай болгоно. Ард иргэдээс ирдэг гол шүүмжлэл бол төрийн алба тогтворгүй байна гэж байгаа. Сонгуулийн дараа өөрчлөгдөж байна. Үүнээс болоод төрийн албаны чадавхи муудаж байна. Тийм учраас төрийн албыг аль болох улс төрөөс ангид байлгаж, тогтвортой болгоход энэ хууль чиглэгдэж байна. Тухайлбал “шатлан дэвших”-ийг энэ хуульд гол болгож өгсөн. Яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга хийх хүн бол төрийн албанд 16 жил ажилласан байх ёстой гэдэг шаардлага тавьж байгаа. Яамны газрын дарга хийх хүн бол доод тал нь найман жил ажилласан байх ёстой. Хоёрдугаарт, төрийн албанд орж байгаа хүнийг хариуцлагажуулж өгч байгаа. Тухайлбал, төрийн албанд орох хүн онц хүнд гэмт хэрэг болон эрүү, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож өмнө нь шүүхээр ял шийтгүүлж байсан бол төрийн албанд орохгүй.

Нөгөө талаар хууль бус томилгоо хийх, энэ нь Төрийн албаны зөвлөл болон Шүүхийн байгууллагаар тогтоогдсон тохиолдолд тэндээс гарах хохирлыг шийдвэр гаргасан албан тушаалтан өөрөө харуцна. Энэ бол төрийн албыг хариуцлагажуулж өгч байгаа. Гуравдугаарт нь, төрийн албан хаагчдын ажлын үнэлгээг тодорхой болгож өгч байгаа юм. Тэдний ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, үнэлгээг тодорхой болгож өгч байгаа. Дөрөвдүгээрт нь, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг энэ хуулиар зохицуулж өгөхөөр оролдож байгаа” гэв.

Төрийн албаны чиглэлээр Засгийн газрын үүргийг нэлээд өргөтгөж өгсөн гэнэ. Төрийн албаны зөвлөлийн эрх үүргийг нэмэгдүүлсэн юм байна. Тухайлбал, хууль бусаар халагдсан албан хаагчийн асуудлыг ТАЗ хүчингүй болгох эрхтэй. Өмнө нь хүчингүй болгох эрхийг зөвхөн шүүх шийддэг байсан. Энэ мэтчилэн төрийн албыг хариуцлагатай, тогтвортой болгох чиглэлээр хуулийн төсөл боловсруулж байна. Хуулийн төсөлд төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулахаар Олон нийтийн зөвлөл байгуулж байгаа. Олон нийтийн зөвлөл хараат бус байх аж.

Мэдээллийн дараа зарим асуултад хариулт авлаа.

-Давосын эдийн засгийн

чуулган боллоо. Энэ чуулган дээр Монгол Улс санхүүгийн хямралд өртөх эрсдэлгүй орнуудын жагсаалтыг тэргүүлсэн гэнэ. Энэ асуудлыг бүлгийн хуралдаанаараа ярив уу?

Д.Хаянхярваа: Давосын чуулга уулзалтын талаар бүлгийн хуралдаанд дээр тухайлан яригдаагүй. Энэ асуудал манай хувьд хүнд асуудал байгаа. Санхүүгийн хувьд бид өнөөдөр амаргүй байна. Гэхдээ бүхнийг хохирол багатайгаар даван туулах арга замуудыг УИХ-ын болон Засгийн газрын төвшинд хайж, ажиглаж байна. Гадаад улс орнуудтай банк, санхүүгийн чиглэлээр хамтарч ажиллахаар тодорхой яриа хэлцэл хийж байгаа. Нэн ялангуяа БНХАУ-тай харилцаагаа хэвийн хэмжээнд байлгахар бүх шатандаа хэлэлцэж, нааштай алхмууд гарч байгаа. Эдийн засаг, санхүүгийн асуудлаа улс төрөөс ангид, популист цуурхлаас ангид байлган, төрийн нэгдсэн бодлогоор зохицуулж явах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа. Энэ асуудлаар МАН-ын бүлэг эдийн засгаа яаж тогтворжуулах талаар санал солилцоно.

-Нүүрсний үнийг 71.5 ам.доллар гэж хамгийн дээд ханшаар гэрээ байгуулж чадлаа гэж байна. Энэ нь манай эдийн засагт ямар ач холбогдолтой байх бол?

Д.Хаянхярваа:

Засгийн газар шийдвэр гаргаж Тавантолгойн ордоос гарч байгаа нүүрсний үнийг тендэр шалгаруулан, 71.5 ам.доллараар тогтоосон юм билээ. Өнөөдөр Тавантолгойн ордын төсөл хөтөлбөрийг цааш үргэлжлүүлэх чиглэлээр гэрээ хэлцэл хийгдэж байгаа. Энэ үнийн дүн тодорхой төвшинд нөлөөлөхгүй байх. Засгийн газар өөрсдийн хувилбараа хэзээ оруулж ирэх асуудлаар ярилцсан.

-“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг төр авах тухай мэдээлэл гарсан. Энэ талаар бүлгийн хурлаар ярив уу?

Д.Хаянхярваа:

МАН-ын дарга М.Энхболд Эрдэнэтийн 49 хувийг улсад буцааж авахаар боллоо гэсэн худал мэдээлэл өнгөрсөн долоо хоногт цацагдсан. Өнөөдөр бүлэг дээр “Эрдэнэт”

үйлдвэртэй холбоотой асуудал яригдаагүй. 49 хувийг шалгах тухай асуудлаар УИХ-ын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Энэ долоо хоногт төр ажилтны хэсэг зарчмын дагуу байнгын хороон дээр танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл УИХ дахь намын бүлгүүдэд танилцуулна гэсэн байр суурьтай байгаа. Иргэдэд хандаж хэлэхэд Тавантолгой, “Эрдэнэт” үйлдвэртэй холбогдсон асуудлаар худал маягийн мэдээлэл нэлээд цацагдаж байна. Энэ худал асуудал манай гадаад дотоодын харилцаанд сөргөөр нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, бүлэг шийдвэр гаргаад “Эрдэнэт”-ийн 49 хувийг буцаагаад авчих юм байна. Тавантолгойн төслийг 400 сая ам.доллараар худалдчих юм байна гэдэг худал мэдээллийг түгээснээр эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ.

-Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулахдаа Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох болов уу?

Д.Тогтохсүрэн: Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнийг гурван гишүүнтэй болгоно. Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас томилдог байна. Гэхдээ энэ зөвлөл хугацаагүй томилдогдоно. Зөвхөн хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгддөг болгох чиглэлийн өөрчлөлтийг хийхээр тооцож байгаа.

-Төрийн өмчит аж ахуйн нэгжийн асуудлыг энэ хуулийн төсөлд тусгах уу?

Д.Тогтохсүрэн:

Төрийн өмчит аж ахуйн нэгжийн асуудлыг энэ хуулийн төсөлд тусгахгүй. Зөвхөн төрийн захиргаа, улс төрийн албан тушаал, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалын хүрээний асуудлыг зохицуулах юм.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭЛЭЛ

УИХ дахь АН-ын бүлэг хуралдсангүй

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр хурлаа цуцалж, ирэх лхагва гарагт хуралдахаар болсон тухайгаа мэдэгдлээ. Учир нь тус намын даргын

сонгууль болох гэж байгаа тул ихэнх гишүүд нь орон нутагт томиллолтоор, зарим нь гадаадад томиллолттой ажиллаж байгаа тул өнөөдрийн бүлгийн хурлыг

хойшлуулжээ. Ардчилсан намын бүлэг намын даргын сонгуультай холбоотойгоор сүүлийн хэдэн долоо хоногт хуралдаагүй билээ.

Зам, тээврийн салбарын төсөл, хөтөлбөрүүд урагшлах нь

Ж.МЯГМАР

Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагууд ээлжит шуурхай хуралдаанаа өчигдөр зохион байгуулла. Энэхүү шуурхай хуралдаанаар салбарын хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай, тулгамдаад байгаа асуудлаа хэлэлцэж, хэрхэн хугацаа алдалгүй, түргэн шуурхай шийдвэрлэх талаараа хэлэлцсэн юм. Өнгөрсөн долоо хоногт Бээжин хотноо зохион байгуулагдсан “Торгоны замын ач холбогдол” хөрөнгө оруулалтын форумд, Монголын талын 80 гаруй төлөөлөгчдийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат ахлан оролцсон. Энэхүү хурал, уулзалтаар Монгол Улсад хэрэгжих авто зам

болон төмөр замын томоохон төсөл, хөтөлбөрүүд урагшлах нь тодорхой болсон талаар тус шуурхай хуралдаанаар салбарын сайд мэдээллээ. Тиймээс бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө төлөвлөгөө гарган ажиллах, талуудын уулзалтуудыг шат дараатайгаар зохион байгуулж, ажил хэрэг болгохыг холбогдох газруудад үүрэг болголоо. Мөн агаарын зорчигч тээврийн үндэсний авиа компаниудад агаарын хөлгийн нисэх багийн мэргэжил, туршлага, шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавихаар болсон байна. Түүнчлэн уурхай, тээвэр, хилийн боомтын асуудлыг цогцоор нь хэрэгжүүлэх, хоногийн нэгдсэн графикаар зохион байгуулахаас гадна

Ганцмодны боомтыг 24 цагаар ажиллуулах талаар БНХАУ-ын талтай өндөр дээд хэмжээнд асуудлыг тавьжээ. Тус хурлаар утаатай тэмцэх ажлын хүрээнд УБГЗ-ын галт тэргэнд утаагүй түлш ашиглах, автобусанд утааны шүүлтүүр байрлуулах, хуучин автомашины байгаль орчинд хортой эд ангиудыг хэрхэн шийдвэрлэдэг талаарх судалгаа гаргах зэрэг үүргүүдийг салбарын сайд өглөө. Зам, тээврийн салбарт ажиллаж буй 20 гаруй мянган ажилтан, албан хаагчид байдаг бөгөөд тэдгээрийн шинэ санал, санаачлага, бүтээлч сэтгэхүйг дэмжих үүднээс ажилтан бүрт нэг нэг бүтээлч ажил хэрэгжүүлэх үүрэг өгөх талаар салбарын сайд шуурхайн зөвлөлд даалгажээ.

М.ЭНХБОЛДЫН

хожимдсон ухаарал

Энэ удаагийн эрх баригчид харин ч нэг гадаад томиллолтод гар татахгүй байгаа. Учир нь УИХ-ын дарга болоод УИХ-ын гишүүд, сайд нар айлчлал нэртэй аялалд бөөн бөөнөөрөө явдаг мода дэлгэрүүлчихсэн гэхэд хилсдэхгүй. Тухайлбал, хамгийн сүүлд УИХ-ын дарга М.Энхболд өөрийн “сүрэг”-ээ дагуулаад айлчлал нэрт “аялал” хийгээд ирсэн. Албан бус эх сурвалжийн мэдээлж буйгаар ОХУ-д айлчлах үеэрээ М.Энхболд хөнгөлөлттэй зээл хүссэн ч бүтэлгүйтсэн гэх юм билээ. Өөрөөр хэлбэл, ямар ч үр дүнгүй айлчлал хийсэн гэсэн үг. Тэгвэл эрхэм УИХ-ын дарга өөрөө сүрэг сүргээр нь гишүүд дагуулж “зугаалахдаа” шал тоохгүй байгаа хэрнээ Засаг дарга нарыг загнаад авсан гэнэ шүү. Тодруулбал, энэ сарын 5-6 өдрүүдэд Төрийн ордонд болсон аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын семинарын үеэр тэрбээр “Гадаад томилолт дэндүү их байна. Яах вэ, зайлшгүй шаардлагатай бол явах нь зөв. Шууд харилцаа бол чухал. Гэхдээ гадаад харилцаанд зарцуулж байгаа хөрөнгө болон гадаад харилцаанаас олж байгаа үр дүн хоёрыг аймаг, аймагтаа нэг бодож, тооцож үзээрэй. Аль нь илүү ашигтай байна гэдгийг. Би сүүлийн 5-6-ны сарын хугацаанд гадаадад хийсэн томилолтын судалгааг хийлгэж үзсэн. Гэтэл нэлээд урт жагсаалт гарсан. Явцгаах нь явжээ. Үр дүн яасан бэ. Тиймээс үр дүнгүй гадаад томилолтыг энэ эдийн засаг хүнд үед жаахан тэвчвэл яасан юм бэ” хэмээн шүүмжилсэн гэнэ. Үүнээс үзэхэд эрхэм дарга маань үр дүнгүй айлчлал хийж ирчихээд, гадаад томилолтод ямар их мөнгө цацаж байгаагаа гэнэт ухамсарласан бололтой дөг шүү.

Гэрэл зургийг Г.Аргуужин

ЦАГ ҮЕ

PHOTO NEWS



Гэрлэж буй Г.АРИУУЖИН

Ардчилсан намын даргад нэр дэвшигчид өмчлөх Ардчиллын дууч, "Хонх" хамтлагийн дуучин С.Цогсайхан агсны хошоонд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлээ.

МЭДЭЭЛЭЛ

Хүүхдээр морь унуулсан тохилдолд хуулийн хариуцлага хүлээлгэнэ гэв

Олон улсын болоод дотоодын хүүхдийн эрхийн байгууллагууд олон жил хурдан морь унаач хүүхдийн эрхийг ярьсны дүнд олон нийтийн ойлголт хандлага, эрх зүйн орчин сайжирсаар байна. Гэсэн хэдий ч жил жилийн цагаан сарын өмнөхөн "тухайн жилийнхээ өнгийг үзэх" гэж Дунжингарав гэх мэт хаврын томоохон уралдаануудыг идэр есийн хүйтэнд зохион байгуулсаар ирсэн. Өвлийн уралдааныг хориглож, хаврын уралдаан гэж нэрийдсэн томчуудын зугаанаас үүдэн сүүлийн гурван жилийн байдлаар 330-580 хүүхэд хүнд, хөнгөн бэртэл авсан тухай мэдээ бий. Тэгвэл энэ оноос өвлийн

уралдааны үеэр хүүхдээр хурдан морь унуулсан тохиолдолд унаач хүүхдийн эрх Хөдөлмөрийн сайдын 2016 оны хоёрдугаар сарын 08-ны өдрийн тушаалаар баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын дагуу хамгаалагдах юм байна. Тодруулбал, Жил бүрийн арваннэг дүгээр сарын 01-ээс тавдугаар сарын 01-ийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа үсэргэнд хүүхдээр хурдан морь унуулбал Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай, хууль, Захиргааны хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр болжээ. Энэ мэтчилэн хүүхдийн эрхийн

байгууллага болоод төр засгаас уг асуудалд анхаарал хандуулж, эхлүүлсэн ажлууд үр дүнгээ өгсөөр байна. Тухайлбал, 2011 онд "Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавих стандарт"-ыг батлуулж, хурдан морь унаач хүүхдүүд хамгааллын хувцас хэрэглэл өмсдөг болж, холбогдох байгууллагууд аюулгүй байдалд нь анхаарал тавьж хууль, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг тогтмол хянадаг болсон юм. Үүний үр дүнд мориноос унаж бэртэх хүүхдийн тоо 2011 онтой харьцуулахад мэдэгдэхүйц буурсан сайн мэдээг ч мөн дуулгаж байна.



ДАРХАН-УУЛ АЙМАГ

Монголын хамгийн том нарны цахилгаан станц нээлтээ хийлээ

Дархан-Уул аймгийн I багийн нутаг дэвсгэрт байрлах 10 мвт хүчин чадал бүхий нарны цахилгаан станц энэ сарын 19-нд нээлтээ хийлээ. Нээлтийн үйл ажиллагаанд Эрчим хүчний сайд П.Ганхүү, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан, Зохицуулагч Д.Бассайхан, Ажлын албаны дарга Г.Эрхэмбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаяр, Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Масато Такаока болон аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат, аймгийн Засаг дарга С.Насанбат зэрэг албаны төлөөллүүд оролцож, хүндэтгэлийн туузыг хайчилсан юм. Дарханы нарны цахилгаан станц байгуулах ажлыг Нарны эрчим хүчний чиглэлээр 30 гаруй жил дагнан ажилласан, Физик-математикийн шинжлэх ухааны доктор Н.Энэбиш, Дарханы дулааны цахилгаан станцыг 10 гаруй жил удирдсан, Монгол Улсын Зөвлөх инженер Б.Мандалбаяр тэргүүтэй эрчим хүчний салбарт олон жил ажилласан мэргэжлийн туршлагатай баг, Японы "Sharp" корпораци, "Shigemitsu shoji" компанийн эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлжээ. Тус нарны станцыг дотоодын "Solar power international", Японы "Sharp" корпораци, "Shigemitsu shoji" компани хамтран байгуулсан бөгөөд жилд 14.1 сая кВт/цаг эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Цахилгаан станц ашиглалтад орсноор 20 мянган айл өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах боломж бүрдэх аж. Улмаар жилд 14.746 тонн хүлэмжийн хий ялгаруулахаас сэргийлэх ач холбогдолтой хэмээн "Solar power international" компанийн гүйцэтгэх захирал Б.Мандалбаяр нээлтийн үйл ажиллагааны үеэр онцлоло. Станцын цахилгааны тоног төхөөрөмжүүд нь манай орны -30-40 хэмийн хүйтэн эрс тэс нөхцөлд найдвартай, өндөр үр ашигтай хэвийн ажиллаж байхаар тооцоолсон бөгөөд Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ компанид эрчим хүч нийлүүлж эхэллээ.

ДУНДГОВЬ АЙМАГ

Цагдаагийн газар 2016 оны үйл ажиллагаагаа иргэддээ тайлагнав

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар Иргэний зөвлөл, аймаг сумын удирдлагууд болон иргэд олон нийтэд 2016 оны үйл ажиллагааны тайлангаа тавьж, арга хэмжээнд оролцсон иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллаа. Дундговь аймаг дахь Цагдаагийн газар 2016 онд гэмт хэрэгтэй тэмцэх, үрдицлэн сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгээ зохих ёсоор биелүүлэн ажиллажээ. Аймгийн чиглэлээд 2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг 8.7, танхай 60, хүчин 50, бусдын эд хөрөнгийг хулгайлах 32.6, малын хулгай

48.4, иргэдийн өмчийн хулгай 25.8, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 37.1, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 29, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 14.8, бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг 44, нас барсан хүний тоо 48 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 67.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өсчээ. Мөн торгосон торгуулийн хэмжээ 173.3 саяар буюу гурав дахин өссөн байгаа нь эрх зүйн зөрчилтэй тэмцэх чиглэлээд тус Цагдаагийн газраас зохион байгуулсан ажлын үр дүн нэмэгдэж, гэмт хэргийн илрүүлэлт тодорхой хувиар өссөн байна.

ОРХОН АЙМАГ

Засаг дарга төрийн байгууллагын удирдлагуудтай "Хариуцлагын гэрээ" байгууллаа

Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут төрийн болон төрийн өмчит байгууллагуудын удирдлагууд, хоёр сумын Засаг дарга болон өөрийн орлогч нартай 2017 оны үр дүн, хариуцлагын гэрээ, батламж, хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. Тодруулбал, аймгийн Засаг даргын орлогч А.Тувшинжаргал, С.Батжаргал нартай "Батламж", Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг дарга нартай "Батламж" үр дүнгийн гэрээ байгууллаа. Түүнээс гадна Засаг дарга өөрийн харьяаны эхлээс, газар, агентлаг, албадын дарга нартай "Үр дүнгийн гэрээ" байгуулсан юм. Үр дүнгийн гэрээнд ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү болон 20 орчим байгууллагын удирдлагууд гарын үсэг зурлаа. Харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагатай Засаг дарга "Хамтран ажиллах" гэрээ байгууллаа. Тодруулбал, "Эрдэнэт Ус" ДТС ОНӨХК, Цэцэрлэгжүүлэлт-Ногоон байгууламж, Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮТ, Хот тохижуулах газар ОНӨҮТ, Нийтлэг үйлчилгээний албаны дарга нар Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулав. Энэ үеэр аймгийн Засаг дарга Д.Батлут "2017 он бол их ажлын гарааны жил. Энэ жил бид бүтээн байгуулалтын болон нийгэм, эдийн засгийн өсөлтийг хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьж байна. Тиймээс үр дүнгийн болон хамтран ажиллах гэрээнд 18 арга хэмжээг тусгасан. Эдгээрийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна" гэсэн юм. Үр дүнгийн болон хамтран ажиллах гэрээнээс гадна бүх байгууллагын удирдлагууд "Хариуцлагын гэрээ"-нд гарын үсэг зурлаа. Энэхүү гэрээ нь Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд байгууллагын хэмжээнд сахилга хариуцлагыг сайжруулж, иргэдээс гарсан санал хүсэлтийг тогтмол сонсож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байна. Мөн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулах болон хүний хөгжилд чиглэсэн орон нутгийн бодлогыг дэмжин хамтран ажиллах талаарх заалтуудыг тусгажээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
2016 оны 12 сарын 24 өдөр																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
2. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Захирал П.Дэлгэрнанд авалтасугай.																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
Шүүх хуралдааны үед цагдаагийн нэг алба хаагч байсан. Өнөөдрийн байдлаар манай шүүх тун ачаалал ихтэй ажиллаж байгаа учраас харуул хамгаалалтын хувьд цагдаа нар анхаарал хандуулахгүй бол хүн хүч хүрэлцэхгүй тохиолдол их байна. Өмнө нь Тахарын байгууллага энэ үүргийг гүйцэтгэж байхад ийм тохиолдол гарч байгаагүй. Тахарын алба татан буугдсанаар шүүхийн аюулгүй байдал энэ мэтчилэн алдагдаж, цаашид ямар ч ноцтой байдалд хүрч болзошгүй байдалд байна. Мөн шүүгдэгч этгээд хоолойгоо юугаар зүссэнийг цагдаагийн байгууллага тогтоогоогүй байна. Учир нь ямар нэгэн төмөр, ирт зүйл байгаагүй, шүүгдэгч гавгүй байсан. Цагдаагийнхан одоогийн байдлаар хумсаараа судсаа ханасан байж магадгүй гэж байгаа ч оёдол тавиулсан, цус нь олгойдож байсан нь эргэлзээтэй. Шүүх хурлын үеэр шүүх танхимын зарим эд зүйлийг гэмтээсэн. Уг нь шүүгдэгчийг нэгжиг шалгасны дараа шүүх танхимд оруулах ёстой. Тухайн өдөр цагдаагийн ажилтан шалтгалт хийсэн эсэх талаар мэдээлээгүй. Тус шүүхийн хамгаалалтад нийт 12 цагдаа ажилладаг бөгөөд хурлын долоон танхимд дөрвөн цагдаа хамгаалалтад ажилладаг.

...Шүүх хуралдааны үед цагдаагийн нэг алба хаагч байсан. Өнөөдрийн байдлаар манай шүүх тун ачаалал ихтэй ажиллаж байгаа учраас харуул хамгаалалтын хувьд цагдаа нар анхаарал хандуулахгүй бол хүн хүч хүрэлцэхгүй тохиолдол их байна. Өмнө нь Тахарын байгууллага энэ үүргийг гүйцэтгэж байхад ийм тохиолдол гарч байгаагүй...

...Шүүх хурлын танхимд Тахарын алба, Цагдаагийн алба хаагчид чиг үүргийн хувьд ижил шүүх танхимын аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Түүнээс биш Тахарын алба байлаа гээд дээрх шиг үйл явдал болохыг урьдчилан таамаглаж хамгаална гэж байхгүй...



Ё.Лхагвасүрэн: Тахарын алба байлаа гээд дээрх шиг үйл явдал болохыг урьдчилан таамаглаж хамгаална гэж байхгүй

/ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн ажилтан/

Шүүх хурал бол даргалагч шүүгчийн бүрэн удирдлагаар явагддаг. Шүүх хурлын танхимд болж байгаа бүх хөдөлгөөн шүүхийн протоколд бичигдэж явдаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн нарийн дэг журам үйлчилдэг. Харин шүүх хуралд оролцож байгаа цагдаагийн алба хаагч нь уг танхимд нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үүрэг гүйцэтгэдэг. Тухайн шүүгч нь гэмт хэрэгтнийг гавла, шүүгдэгчийн аюулгүй байдлыг ханга гээгүй бол цагдаа шүүгдэгчийг гавлах, харгалзаж биед нь хүрэх гэх мэт үйлдэл хийж болохгүй. Тухайн шүүх хурлын бичлэгнээс үзэхэд шүүгдэгч хоолойгоо зүсэхэд нь цагдаа гарнаас нь татаж болуулж байгаа дүрс байна. Тухайн цагдаа өөрийнхөө хийх үүргийг гүйцэтгэсэн. Үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа шүүх хурал эхлэхээс өмнө танхимд орох шүүгдэгчийн биед үзлэг хийх ёстой. Үзлэгээ хийж журмын дагуу ажилласан. Одоогийн байдлаар шүүгдэгч хумсаараа өөрийгөө гэмтээсэн гэсэн дүгнэлт гарсан. Шүүгдэгч Б нь өмнө нь хоёр удаа ял шийтгэгдэж, Өршөөлийн хуулиар суллагадаг давтан гэмт хэрэг үйлдээд ял сонсохдоо дээрх үйлдлийг хийсэн. Шүүхийн танхимд амиа хорлохыг завдсан шүүгдэгч Б-д Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл буюу шүүх танхимд танхайрсан гэх үндэслэлээр дахин хэрэг үүсгэж Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст шалгаж байна. Шүүх хурлын танхимд Тахарын алба, Цагдаагийн алба хаагчид чиг үүргийн хувьд ижил шүүх танхимын аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Түүнээс биш Тахарын алба байлаа гээд дээрх шиг үйл явдал болохыг урьдчилан таамаглаж хамгаална гэж байхгүй.

Сэтгүүлчийн дүгнэлт

ТАХАРЫН АЛБААР ХҮРТЭЛ УЛСТӨРЖИХ ХЭРЭГ БАЙСАН УУ

Н.ПУНЦАГБОЛД

Тахарын алба гэдэг гэрч, хохирогчийг хамгаалах бүхэл бүтэн том бодлого байлаа. Гэтэл 2014 оны сүүлчээс эхлээд тахарын албыг татан буулгах асуудлыг ярьж эхэлсэн. Өөрөө санаачилсан юм болохоор УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжин жаал хамгаалсан байх. 2014 оны арванхоёрдугаар сарын 4-нд хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны үеэр гэрбээр “Та нар судалгааны ажлаа сайн хийсэнгүй дээ. Цагдаагийн байгууллага чинь одоо хэвийн үйл ажиллагаагаа явуулахад 1250 орон тоо дутуу явж байгаа. Үүнийг өмнөх Засгийн газрын Ц.Нямдорж сайд ч хэлж байсан. Гэтэл ийм хүрэлцээгүй байгууллага дээр Тахарын албаны гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг нэмж байгаа үед дийлэхгүй. Гэрч хохирогчийг, шүүх үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийг байхгүй болгож болохгүй” хэмээн бүр ёр юм шиг хэлж байж. Тэр дундаа “Шүүх ажиллагааны хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийг байхгүй болгох нь” гэж ярьж байсан байгаа юм. Гэтэл 2016 оны долдугаар сарын 21-ний өдөр Тахарын албыг татан буулгах шийдвэрийг шинэ Ерөнхий сайд ажлаа авсан даруйдаа л гаргачихсан. Хэрэггүй алба, төсвийн мөнгийг дэмий үрж байна гэх маягийн шалтгаанаар татан буулгасан.

Мэдээж нарийн ярьвал янз бүрийн албан шалтгаан тоочсон л доо. Гэтэл Тахарын алба яг хэрэггүй байсан уу. Дахиад сануулъя. Тахарын албаны газрын үндсэн чиг үүрэг нь шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Энэ зорилтын хүрээнд шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахнуулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, хохирогч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, ялтан шилжүүлэх болон хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэдэг байсан юм. Хамгийн хэрэгтэй алба. Гэтэл яг үнэндээ МАН улстөржөөд, АН-ын үед хийсэн ажлуудыг дарах, харлуулах, өөрчлөх их аяныхаа хүрээнд дайгаад л арилгачихсан алба. Үүнээс нь болоод шүүх хурлын үеэр хэрэгтэн амиа хорлохыг завдлаа. Ингэж дүгнэж болохоор л байна. Яах вэ, цагдаагийн байгууллагынхан бол Тахарын алба байсан бол ингэхгүй байсан гэж ярихгүй. Тэгэх ч боломжгүй. Гэхдээ энэ хэрэг яах аргагүй “Тахарын алба байсан бол...” гэдэг өнцгийг гаргаад ирж байна.

Энэ удаад яах вэ, хэрэгтэн өөрийнхөө амийг хорлох гэж завдлаа. Эсрэгээрээ шүүгчийн амь насанд халдах оролдлого хийсэн бол яах вэ. Өөрийнхөө хоолойг зүсч дөнгөж байгаа /Хумсаараа ч байна уу, хутга, шөвөг, төмөр ч байна уу/ хүн бусдынхыг ч зүсчихэж чадна. Хэрвээ тэгсэн бол “Бид шалгасан. Манай албан хаагч ном журмын дагуу ажилласан” гэж хэлээд өнгөрөх асуудал биш л болно. “Тахарын албан байсан бол” гэдэг яриа бүр ч хурцаар яригдаж, асуудал болох байлаа. Харин хэрэгтэн өөрийнхөө амийг хорлох гэсэн болохоор нэг их асуудал болж, дээшээ дэвэрсэнгүй. Түүнээс биш Тахарын алба яг үнэндээ үгүйлэгдлээ. Хэрэгтэй л байж. Гэвч улстөржилт гэдэг Монголд хэрээс хэтэрчихсэн юм болохоор нэг намын хийсэн ажлыг нөгөөх нь гарч ирч баллуурдсаар л дуусах нь. Зөв ч бай, буруу ч бай. Арай л тэр намын үед барьсан барилга гээд нураах нь холгүй л байх юм. Уг нь зөвийг нь үлдээгээд, хэрэгжүүлээд, залгамжлаад явдаг бол сайнсан. Төрийн бодлого бүхэн өөр намынх л бол буруу байна гэж байхгүй шүү дээ, уг нь.

ДЭЛХИЙ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

**ДОНАЛД ЖР ТРАМП
/39 НАСТАЙ/**

Доналд Жр Трамп эдүгээ таван хүүхдийн эцэг. Ерөнхийлөгч эцэг нь түүнийг 12 настай байхад ээжээс нь салж байжээ. Дүү нараасаа ялгаатай нь гэр бүл салалтын хор уршгийг мэдрэх хангалттай насан дээрээ байсан гэдэг. Доналд Жр Трамп өвөөтэйгөө тун ч дотно өсчээ. Гэхдээ түүний өвөө Милос Зелнисек 1990 онд таалал төгссөн бөгөөд үүнээс төд удалгүй буюу хоёр жилийн дараа эцэг, эх нь тус тусын зам мөрөө хөөхөөр болж байв. Тэр өвөөгийнхөө хамт Прага хотоос холгүй зун бүр хоёр долоо хоногийг ан хийх, загасчилхад зориулдаг байжээ. Тэр угтаараа Доналд Жр Трамп чех хэлээр чөлөөтэй ярьдаг. Өвөөтэйгөө хэр их дотно байсны илрэл нь болгож, тэрбээр хүүгээ өвөөгийнхөө нэрээр Тристан Милос гэж нэрлэжээ. Тэрбээр



АНУ-ЫН ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ГЭР БҮЛТЭЙ ТАНИЛЦ

...Иванка Трамп бол гэр бүлийнхэн дундаа хамгийн амжилттай яваа нь. Тэр Эрик, Доналд нарын хамт Трамп зочид буудлыг байгуулсан бөгөөд үүнийг хажуугаар Nordstrom, Bloomingdale's, Zappos зэрэг хувцас, гутал, гоёл чимэглэл, үнэт эдлэлийн брэндийг гаргаад амжсан сүйхээтэй бүсгүй...

байгууллагаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт манлайлах үүрэгтэй оролцдог ажээ. Доналд Жр Трамп эцгийнхээ нэгэн адил эхнэртэйгээ загварын шоуны үеэр танилцаж байжээ. Түүний эхнэр нь загвар өмсөгч Ванесса бөгөөд хосууд долоон жил ханилдахдаа таван хүүхэдтэй болсон байна.

**ИВАНКА ТРАМП
/35 НАСТАЙ/**

Иванка Трамп бол гэр бүлийнхэн дундаа хамгийн амжилттай яваа нь. Тэр Эрик, Доналд нарын хамт Трамп зочид буудлыг байгуулсан бөгөөд үүнийг хажуугаар Nordstrom, Bloomingdale's, Zappos зэрэг хувцас, гутал, гоёл чимэглэл, үнэт эдлэлийн брэндийг гаргаад амжсан сүйхээтэй бүсгүй. Түүнчлэн, нэгэн үе загварын тайзыг чимж явсан бөгөөд сэтгүүлийн ковер болж байжээ. Эдүгээ Трамп байгууллагын дэд Ерөнхийлөгч. Энэ албан тушаалд тэрбээр шууд л очиж байсангүй. Коллежоо төгссөнийхөө дараа үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгч Брюс Ратнертэй нэг жил хамт ажиллан туршлагажиж байжээ. Ийнхүү гэрээ хэлэлцээр, загварын чиглэлээр мэргэшсэн Иванка Трамп эцгийнхээ компанид 2005 онд орж байв. Гэхдээ энэ сарын эхээр тэрбээр Трамп байгууллагаас гарч, Вашингтон ДС хот руу нүүх бэлтгэлээ базааж эхэлсэн билээ.

Учир нь түүний нөхрийг Доналд Трамп Цагаан ордон дахь өөрийн зөвлөхөөрөө томилсон юм. Үзэсгэлэнт Иванкагийн нөхөр нь ч бизнесийн салбарт нэлээд амжилт олсон гэр бүлээс гаралтайн дээр үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч. Тэрбээр хадам эцгийнхээ хамгийн итгэлт зөвлөх гэдэг. Иванка Трамп Жаред Кушнер нар 2009 онд гэр бүл болсон бөгөөд эдүгээ гурван ч хүүхдийн эцэг, эх болжээ.

ЭРИК ТРАМП

Эрик Трамп эдүгээ 33 настай. Түүний хувьд бусдыгаа бодвол олон нийтийн хараанд өртөх тун дургүй нэгэн байжээ. Тэрбээр нэг удаа Нью Йорк Таймс сэтгүүлд Доналд Жр түүний багш, Иванка яг л хоёр дахь ээж шиг нь байдаг байсан тухай дурссан байдаг. Эрикийн хувьд сургуулиа төгссөний дараа аавынхаа компанид орсон бөгөөд эдүгээ мөн л дэд Ерөнхийлөгчийн албан тушаалтай. Тэр мөн гэрлэсэн. 2012 онд тэрбээр таван жил үерхсэн найз бүсгүй Лара Юнаскатай “Север Спрингс”-г сүй тавьж байв. Ингэхдээ сүйт бүсгүйдээ Иванка Трампын үнэт эдлэлийн цуглуулгаас хамгийн тансаг бөгжийг сонгон бэлэглэж байсан гэдэг. Юнаска Тв продюссер байв. Тэдний хурим Флоридад Трамп Мар-а-Лагод болж, 400 гаруй зочин хүрэлцэн ирж байжээ.

Хуримынх нь үеэр Эрикийн хүргэн ах Жаред шинэхэн бэрдээ “Энд чи зөвхөн гэр бүлээ олж буй юм биш. Чи твиттерт зургаан сая дагачтай болох гэж байна” гэж хэлж байсан гэнэ. Түүнчлэн, Эрик Трамп дарсны үйлдвэр, Виржиниа мужид маш том усан үзмийн цэцэрлэгийн талбай, бас өөрийн Эрик Трамп санг эзэмшдэг.

ТИФФАНИ ТРАМП

Доналд Трампын хоёр дахь эхнэр Марла Матлесаас төрсөн Тиффани Трамп эдүгээ 23 настай. Тэрбээр саяхан Пеннсилванийн их сургуулийг төгссөн. Эцэг нэгтэй эх ондоо ах эгчээсээ ялгаатай нь Тиффани эцгийнхээ оффист тоглож өсөөгүй юм. Харин Лос-Анжелесын зах

хэсэгт ээжийнхээ хамт өсчээ. Түүний хувьд инстаграмм хуудасны идэвхтэй хэрэглэгч гэнэ. Загвар өмсөгч, дуучны чиглэлээр өөрийгөө сорьж эхэлсэн бүсгүй 2011 онд анхны дуугаа гаргасан нь “Like a bird” юм байна. Тэр энэ зун “Warby Parker”-г дадлага хийсэн бөгөөд хуулийн чиглэлээр элсэлтийн шалгалт өгөхөөр бэлтгэж буй аж. Тэр мөн аялах дуртай нэгэн.

БАРРОН ТРАМП

Доналд Трампын одоогийн эхнэр, загвар өмсөгч асан Мелани нэг хүү төрүүлсэн нь Баррон Трамп. Хүү 10 настай. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч нэг удаа “Баррон үнэхээр гайхалтай хүү. Маш их хөдөлмөрдөг” гэж дурссан

удаатай. Барроны хувьд ямарваа зүйлсийг бүтээн байгуулах сонирхолтой бөгөөд хийхийг хүссэн зүйлийнхээ ард нь гарах хүртлээ хэзээ ч шантардаггүй гэнэ. Түүнийг заримдаа бага Доналд гэж дууддаг аж. Залуу ов залгамжлагч сул чөлөөт хувцас гэхээсээ илүүтэй костюм өмсөхийг илүүд үздэг. Бас Трамп таур пентхаусын шалны интрьерыг өөрөө гаргажээ. Мөн бэйсбол, теннис тоглох дуртай гэнэ. Эцэг, эх нь түүнийг байнга олны өмнө зүй зохистой байдлаар ил гаргахыг хүсдэг. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн орой эцэг нь ялалтаа зарлах мөчид ч Баррон хамт байсан юм. Гэхдээ нойроо дийлж ядан эвшээлгэж, нүдээ нухалж байсан нь бичлэгт үлдсэн удаатай.

Пеннсилванийн нэр хүндтэй “Hill” сургуулийг төгссөнийхөө дараа эцгийнхээ замналар явах болжээ. Мөн Пеннсилванийн “Вартон” сургуулийг санхүү, үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 2001 онд коллеж төгссөнийхөө дараа Доналд эцэгтэйгээ хамтран ажиллах болжээ. Эдүгээ тэрбээр Трамп байгууллагын Худалдаа, хөгжүүлэлт харилцаан дэд Ерөнхийлөгчөөр ажилладаг. Тэр Энэтхэг, Шотланд, Лас Вегас, Чикагоод Трамп

Сэнүри нам нэрээ шинэчлэхээр болжээ



БНСУ-ын эрх баригч Сэнүри нам нэрээ өөрчлөх болсноо өчигдөр зарлажээ. Тус улсын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз Чой Сун Шил гэгч төрийн тэргүүнтэй дотно байдлаа ашиглан өөрийн байгуулсан сандаа томоохон корпорацнудаас ихээхэн хэмжээний мөнгийг хандив нэрийдлээр төвлөрүүлж байсан нь өнгөрөгч онд ил болсон. Улмаар Ерөнхийлөгч Пак ч найзаа улс төрийн үйл хэрэгтээ оролцуулан хэлэх үгээ хүртэл засуулж байсныг нь нотлох баримт хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд цацагдсаны дараа сөрөг хүчнийхэн болон Соёлийн иргэд долоо хоног бүрийн

амралтын өдрүүдэд эсэргүүцлийн жагсаал зохион байгуулах болсон. Үүний эцэст парламентын гишүүд Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хурааж, ихэнх нь эсрэг харилт өгсөн байдаг. Харин эдүгээ Үндсэн хуулийн шүүх асуудлыг 180 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд энэ хугацаанд өнөөгийн Ерөнхий сайд Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа юм.

Энэхүү дуулиан шуугианы улмаас эрх баригч Сэнүри намын рейтинг огцом унаж, зарим гишүүд нь намаа орхиход хүрсэн. Тэгвэл энэ бүхний эцэст Сэнүри нам нэрээ өөрчлөх шийдвэр гаргажээ. Тус намын Онцгой байдлын комиссын дарга Ин Мюн Жин “Өнөөдрөөс намын шинэ нэрний асуудлыг хэлэлцэж эхэлнэ. Аль болох хурдан хугацаанд нэрээ өөрчлөхөөртөлөвлөсөн” гэж сэтгүүлд мэдээлжээ. Сэнүри намын нэр нь “Шинэ ертөнц” гэсэн утгатай аж. Тус нам 1997 онд Ханнара гэх нэртэй байсан бол 2012 оны парламентын сонгуулийн өмнө намдаа шинэчлэлт хийж, сонгогчдоос дэмжлэг авах зорилгоор Сэнүри хэмээн нэрээ өөрчилж байжээ.

Популизмаас Гитлер төрдөг гэдгийг анхааруулав

Ромын пап Францис популизмаас нацист Германы дарангуйлагч Адолф Гитлер шиг удирдагч төрдөг хэмээн анхааруулжээ. АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч Доналд Трамп тангаргаа өргөсний маргааш нь Испанийн “El Pais” гэх сонинд ярилцлага өгөх үедээ Францис шинэ Ерөнхийлөгчийн хил дээр хана босгох, өргөст тор татах

гэх мэтчилэн цагаачлалын эсрэг бодлогыг шүүмжилсэн байна. Ингэхдээ тэрбээр Европ дахь популизмын жишээ болгож, 1933 оны Германыг нөхдөл байдлаас дурьджээ. “Герман удирдагч хүссэн. Германы онцлогийг эргүүлэн авчрах тийм удирдагчийг. Гэтэл тэнд “Би үүнийг чадна” гэж хэлэх Адолф Гитлер гарч ирсэн. Гитлер

удирдагчийн албан тушаалыг булааж аваагүй. Түүнийг германчууд өөрсдөө сонгосон. Гэсэн ч эцэстээ германчууд сүйрэлд хүрсэн” хэмээн пап ярьжээ. Нөгөөтэйгүүр, Францис Доналд Трампыг дүгнэхэд хэтэрхий эрт байгааг онцолж, “Тэр юу хийхийг нь харцгаая. Дараа нь хэн болохыг нь дүгнэе” гэсэн байна.

ЭМГЭНЭЛ



хөгшил хариуцаж байжээ.

1952-1964 онд Прокурорын байгууллагад мөрдөн байцаагч, хэлтсийн прокурор, аймгийн прокурор, хотын прокурорын туслахаар ажиллаж байгаад 1964-1990 онд Цагдан сэргийлэхийн мөрдөн байцаах газарт хэлтсийн дарга, НАХА-ны Цэргийн дээд сургуульд багш, эчнээ оройн салбарын захирлаар ажиллаж байгаад 1990 онд насны тэтгэвэрт гарсан.

1959 онд Хууль цаазын дунд сургууль, 1969 онд ЗХУ-ын Дотоод яамны дээд сургууль төгсөж, хуульч мэргэжил эзэмшсэн бөгөөд 1961 онд Харьков хотод Прокурорын ажилтны 6 сарын курс, 1980 онд Ленинград хотод мөрдөн байцаах ажилтны мэргэжил дээшлүүлэх курст тус тус суралцаж мэргэжил дээшлүүлсэн.

Аавын минь хөдөлмөр зүтгэлийг үнэлэн Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Байлдааны медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль болон Ойн медалиудаар шагнагдсан. Мөн уугуул нутаг Сагил сумынхаа хүндэт иргэн, МАХН-ын ахмад зүтгэлтэн тэмдэг, Цагдаагийн алдар тэмдэг, Онц хилчин тэмдгээр хоёр удаа, системийн дээд байгууллагаас жуух бичиг, баярын бичигээр удаа дараа шагнагдаж байсан.

1951 онд МАХН-д гишүүнээр элссэн, намын үүрийн орон тооны бус нарийн бичгийн дарга, намын комиссын гишүүн, ардын хянан шалгах группийн дарга, Улсын дээд шүүхийн цэргийн колледжид ардын төлөөлөгчөөр сонгогдож байсан зэргээр нам, олон нийтийн байгууллагын сонгуульд ажил хийж явсан билээ.

Аавын минь инээмсэглэл тодруулсан тэр л дүр төрх, ажилсаг хөдөлмөрч, цэвэрч нямбай, хамт олондоо эелдэг, тусч чанарыг гэр бүл, үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхөд, ажлын хамт олон нь үеийн үед дурсан санаж явах болно.

Ум сайн амгалан болтугай.

ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Академик боловсролыг эрхэмлэгч АШУҮИС-ийнхан

Төгсгөл.
Түүрч нь I нүүрт

Түүнээс гадна сургалтын агуулга, хөтөлбөрийн хувьд ямар ажил хийв. Энэ талаар сонирхуулахгүй юу?

Би энэ сургуульд 1990 оноос хойш ажиллаж байна. Тэгэхээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль хэмээх өрх айлд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажил болон сургалтын өөрчлөлтийг бүтцийг нь сайн мэдэх хүний нэг л дээ. Манай сургууль эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг улсын сургууль. Нөгөө талаасаа анагаахын дээд боловсрол олгодог салбарын хамгийн том байгууллага юм. Өнөөдөр манай улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 90 гаруй хувийг АШУҮИС бэлтгэсэн байдаг. Эндээс харахад, манай сургуулийн үйл ажиллагаанаас эрүүл мэндийн салбарын онго төрх тодорхойлогдож байна гэж хэлж болох юм. Тиймээс бид эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон сургалтын чанарыг сайжруулах зорилгыг олон жил тавьж ажиллаж байна. Энэ хүрээнд олон төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээний ажлыг хийлээ. Бид сүүлийн үед хөтөлбөрийн шинэчлэлийг нэлээд эрчимтэй хийсэн. Яагаад гэвэл боловсролын хөтөлбөр гэдэг зогсонги зүйл биш. Үргэлж хувьсан шинэчлэгдэж байдаг. Тиймээс ч ЮНЕСКО-гийн олон улсын боловсролын стандарт ангиллыг БСШУСЯ оруулж ирсэн. Энэ дагуу

ЮНЕСКО-гийн олон улсын боловсролын стандарт ангиллыг БСШУСЯ оруулж ирсэн. Энэ дагуу бид үйл ажиллагаагаа явуулж, сургалтын шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, оюутан болон ажилтнуудаа өсч, дэвжихэд нь тусалдаг.

бид үйл ажиллагаагаа явуулж, сургалтын шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, оюутан болон ажилтнуудаа өсч, дэвжихэд нь тусалдаг. Энэ дундаа бид хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийг нэлээд анхаарсан. Ингээд бид “2+4” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, эхлээд анагаахын суурь боловсролыг хоёр жилийн хугацаанд судлаад дараа нь эмнэлзүйн хичээлүүд үздэг системд орсон. 2016 оны зун эхний суурь боловсролын дамжааны төгсөлтийн оюутнууд мэргэшилгүйг хүссэн чиглэлээр сонгон суралцаж байна. Үүнтэй адил био анагаах, нүүр ам судлал, эмзүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлд ч шинэчлэлүүд хийгдсэн. Мөн бид төгсөлтийн дараах сургалт буюу та бүхний сайн мэддэг резидент эмч бэлтгэх сургалтдаа хөтөлбөрийн шинэчлэл хийлээ. Ер нь бидэнтэй хамтарч ажилладаг гадаадын их

дээд, сургуулийн хөтөлбөр болон сургуульдаа хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдээс харж байхад тухайн хөтөлбөр хэрэгжсэнээр оюутнууд ямар ур чадвар эзэмших, юуг мэддэг болох, ямар хандлагатай байхыг тодорхойлсон баримт бичгүүд байдаг. Тиймээс бид тэр баримт бичгийг өнгөрсөн жил боловсруулж, Оюуны өмчийн газраар батлуулсан. Тэгэхээр манай сургуулийн сургалтын үйл ажиллагаа үр дүнд суурилсан буюу цогц чадамж руу чиглэсэн гэсэн үг. Өөрөөр хэлбэл, бид бүх зүйлийг заах биш, энэ хүмүүс төгсөөд юу хийж чаддаг байх юм гэдэгт чиглэсэн сургалтыг явуулж байгаа юм. Нөгөө талаас оюутнуудынхаа сонгон суралцах, бие даан суралцах боломжийг нэлээд нээж өгч, либерал тал руугаа явж байна.

Танай сургуулийн зорилтыг хүн бүхэн мэдэж байгаа гэхэд хилсдэхгүй. Тэгэхээр хийж,

хэрэгжүүлж байгаа ажлууд чинь олны өмнө нээлттэй байдаг. Ер нь 100 шилдэг сургуульд орох зорилтдоо хүрэхийн тулд ямар ажлыг хийж байна вэ?

Бид Ази, номхон далайн баруун эргийн бүсийн 100 шилдэг сургуулийн нэг болно гэдэг том зорилт тавьсан. Тиймээс ч бидэнд хийх ажил олон байна. Нэгдүгээрт, бид энэхүү зорилтдоо хүрэхийн тулд хүссэн хүсээгүй сургалтын орчноо сайжруулах шаардлага гарч ирсэн. Тухайлбал, номын сангийн хүрэлцээг сайжруулах, дадлага хийх сургалтын эмнэлэгтэй болох гэх мэтчилэн олон шаардлагауд байсан. Гэхдээ бид энэ хүрээнд тодорхой ажлыг хийж, нэлээд ахиц дэвшил гарлаа. Манай сургуулийн шинэ номын сан ашиглалтад орсноор оюутнуудад номын сан хүрэлцээтэй байсан асуудал шийдэгдсэн. Номын сан маань өнгөрсөн жил Монгол Улсын хамгийн эко шийдэлтэй тэргүүний номын сан гэсэн гэрчилгээг авсан.

Одоогийн хууль эрхзүйн байдлаас шалтгаалаад анагаахын оюутнууд практик тал дээр дутуу байх шиг санагддаг?

Анагаахын төгсөгчдөд практик дээр гардан хийх ур чадварыг эзэмшүүлэх нь маш чухал. Тиймээс ч бид оюутнуудаа эмнэлгүүдэд маш их дадлага хийлгэдэг. Яах вэ, одоогийн хууль эрхзүйн байдлаас шалтгаалаад манай оюутнууд шууд хүнд үзлэг хийх эрх нь байдаггүй. Гэхдээ бид энэ асуудлыг шийдэж байна. Жишээлбэл, ур чадварын төвийг шинээр сургалтдаа нэвтрүүлжээ.

Ялангуяа өнгөрсөн жил зургаан өрөө бүхий ур чадварын төвийг шинээр байгуулсан. Дотор, мээ засал, эх барих, хүүхэд зэрэг төвийг байгуулсан. Энэ төвд оюутнууд практик дээр гарахаас өмнө үзлэгийг хэрхэн хийх, яаж оношлох, яаж чагнах вэ гээд бүх зүйлийг хийж сурсны дараа өвчтөнд үзлэг хийх чиглэлийг нэвтрүүлсэн. Энэ бол сургалтын чиглэлээр хийсэн бас нэг инноваци юм. Тэр төвд оюутнуудаас гадна мэргэжил эзэмшсэн эмч нар маань чирж сургалт хийдэг. Маргаашийн хагалгааг бид яаж хийх вэ, дурангийн хагалгаа хийх бол гараа хэрхэн зүгшрүүлэх зэргээр төгсөлтийн дараах сургалтын эмч нар ч хичээллэдэг.

Анагаахын салбарт ажиллагсдын 90 гаруй хувийг танай сургууль бэлтгэж байна. Сүүлийн үед дипломтой ажилгүйчүүд ихсэх боллоо гэж ярьж байна. Танай сургуулийн хувьд энэ тал дээр төгсөгчидтэйгөө хамтарч ажиллах зүйл байдаг уу?

Бид резидент эмч нарыг ажлын байртай болгох тал дээр олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тухайлбал, манай шүдний сургуулийн дэргэд эмнэлэг барьсан. Ирэх сард бүрэн ашиглалтад орохоор бэлтгэл ажлууд хийгдэж байна. Тэр эмнэлэгт манай резидент эмч нар ажиллах боломжийг бүрдүүлсэн. Урьд нь эмч нар л хүнээ үзэн. Резидентүүд хүн үзэх боломж хязгаарлагдмал байсан. Тэгэхээр бид энэ боломжийг нээж өгч

Д.Даваадорж: Их сургуулийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээг үзүүлдэг

/АШУҮИС-ийн их сургуулийн нэгдсэн эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал/

Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг шинэхэн байрандаа ороход тун ойртож байна. Үүнтэй зэрэгцээд сургалтын нэгдсэн эмнэлгээ хүлээж авах, түүнд бэлтгэх зэрэг ажил танай сургуулийн багш, эмч мэргэжилтнүүдийн нуруун дээр буй. Ер нь бэлтгэл ажил хэр жигдэрч байна вэ?

2013 онд бид Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлгийн судалгааны төслийн ажлыг амжилттай дуусгаад, сургалтын эмнэлгийн барилгын ажил амжилттай эхэлсэн. Бид 2018 оны долдугаар сарын 1-нд орчин үеийн багаж, тоног, төхөөрөмжтэй эмнэлгийн барилгыг хүлээж авах юм. Энэхүү орчин үеийн шинэ сургалтын эмнэлэг нээгдсэнээр нийслэл болон Монгол Улсын хэмжээнд гуравдугаар шатлалын эмнэлгийн үйлчилгээг ард түмэнд үзүүлэх боломж нээгдэнэ. Уг эмнэлэг нь эмнэлгийн үйлчилгээнээс гадна төгсөлтийн дараах сургалтын

том төв болно. Ер нь эрдэм шинжилгээний том судалгааны төв гэж ойлгож болно. Одоогийн байдлаар барилгын үйл ажиллагаа тогтвортой явагдаж, багаж, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Мэдээж үүнтэй зэрэгцээд орчин үеийн стандартад нийцсэн тоног, төхөөрөмжтэй эмнэлэгт ажиллах эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлагатай. Тиймээс бид Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран сургалтын нэгдсэн эмнэлэгт ажиллах сургуулийн багш нар болон эмнэлгийн ажилтнуудыг сургаж байна. Тухайлбал, манай улсад шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн мэс заслын сургалт болон эмнэлгийн удирдлага зохнон байгуулалт зэрэг олон сургалтыг явуулж байгаа. Бид шинэ эмнэлгээ Японы менежменттэй орчин үеийн сургалтын том эмнэлэг болгохоор зорьж байгаа юм. Энэ бол манай эмнэлзүйн ажлын нэг хэсэг.

Их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг ес дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд эмч, мэргэжилтнүүд

чадавхижуулах, эмнэлгийн цаг хүрээг өргөтгөх тал дээр олон ажил хийсэн байх?

Манай их сургуулийн сургалтын нэгдсэн эмнэлэг 2008 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. Бид сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлээ. Эрүүл мэндийн даатгалд хэвтэн эмчлүүлэх хэсэг нь орсон. Мөн өнгөрсөн оны долдугаар сард ЭМЯ-аас нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан. Ингэснээр бид Монгол Улсын хэмжээнд мэдрэл, мэс засал, дотор, хүүхэд, гэмтэл, уламжлалт зэрэг долоон чиглэлээр үйл ажиллагаа үзүүлэх бүрэн боломжтой болсон. Манай сургалтын нэгдсэн эмнэлэгт БНСУ-ын зургаан профессор, Япон болон Солонгосын хоёр эмнэлгийн ажилтан ажилладаг. Мөн манай эмнэлэгт Монгол Улсын хэмжээн дэх хоёр, гуравдугаар шатлалын эмнэлэгт хийгддэг мэс заслыг амжилттай хийж байна. Бид Солонгосын зургаан профессорын туршлага болон залуу эмч, мэргэжилтнүүдийн идэвх чармайлтаас хамаараад шинэ технологиудыг нэвтрүүлжээ.

Тухайлбал, дурангийн аргаар дэлүү, гэдэс, бөөрний дээд булчирхай тайрах, цөсний хүүдий авах болон эмгэгтэйчүүдийн зарим мээ заслыг хийж байна. Мөн артер, венийн судасны залгаагуудын хагалгааг ч хийдэг. Үүнтэй холбогдуулан шинэ эмнэлгийн байранд орохоороо бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг хийх саналыг дэвшүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна. Энэ мэтчилэн хийж буй олон ажил бий.

Сүүлийн үед иргэдийн дунд үс уналт маш ихэссэн шүү дээ. АШУҮИС-ийн сургалтын нэгдсэн эмнэлэг үс суулгах ажилбарыг хийхээр төлөвлөж байгаа гэж сонссон. Энэ талаар ярихгүй юу?

Тийм. Бид энэ жил бололцоотой бол үс шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Ер нь манай их сургуулийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж байна. Өнгөрсөн жилд гэхэд 18 мянган хүнд үйлчилсэн байна. Мөн сургуулийн Эрүү нүүрний эмнэлгийн үйл ажиллагаа сайжирч 17 мянга гаруй хүнд үйлчилжээ.

Б.Мөнхбат: Багш нарын эрдэм, шинжилгээний бүтээл дэлхийн анагаах ухааны салбарт хүчтэй байр суурь эзэлж байна

ажлын гол цөмийг гүйцэтгэдэг. Тэгэхээр АШУҮИС-ийн нийт эрдэмтэн, багш нарын 43 хувь нь анагаах ухааны докторын зэрэгтэй байдаг. Энэ утгаараа манай багш нар анагаах эрдмийг оюутнуудад зааж, сургахаас гадна салбарынхаа тулгамдаж буй асуудлыг гаргаж ирэх эрдэм, шинжилгээний ажил хийдэг. Цаашилбал, анагаахын салбарт ямар шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх вэ гэдэгт салбараа манлайлан ажилладаг. Тэгэхээр энэ утгаараа АШУҮИС бол дээд боловсролын төв байгууллагаас гадна эрдэм шинжилгээний төв байгууллага юм. Энэ асуудлыг тодорхой тоо баримттайгаар хэлбэ. Тухайлбал, манай сургуульд 600 гаруй багш ажилладаг. Энэ бол манай их сургуулийн хүний нөөцийн чадавхийг харуулж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл,

нийт багш нарын маань 43 хувь нь анагаахын салбарт тодорхой эрдэм, шинжилгээний ажил хийж гүйцэтгэсэн арвин туршлагатай эрдэмтэд байгаа нь үүнийг нотолж байгаа юм. Ер нь багш нарын маань эрдэм, шинжилгээний бүтээлийн ажил жил ирэх тусам нэмэгдэж байна. Тухайлбал, манай багш нар 2014 оны байдлаар эрдэм, шинжилгээний 1600 гаруй бүтээлийг туурвисан. Эдгээрээс олон улсын өндөр чансаатай сэтгүүлд 30 гаруй бүтээл хэвлэгдсэн. Харин өнгөрсөн жилийн байдлаар манай сургуулийн багш нар эрдэм шинжилгээний 2300 бүтээл хийж, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд 57 бүтээл нь нийтлэгдлээ. Олон улсын нэр хүндтэй эрдэм, шинжилгээний сэтгүүлд өндөр чансааны шалгуур үзүүлэлт гэж байдаг л даа. Манай багш нарын

чансааны үзүүлэлтийн оноо 173-д хүрсэн. Үүнээс манай эрдэмтэн, багш нарын бүтээл зөвхөн Монгол Улсын анагаах ухааны салбарт төдийгүй дэлхийн анагаах ухааны салбарт хүчтэй байр суурь эзэлж байгаа нь харагдаж байгаа юм.

Багш нарын эрдэм, шинжилгээний ажлыг баялаг болгох тал дээр нэлээд ажил хийсэн. Одоогоор хэчнээн гарааны компани ажиллаж байна вэ?

Сүүлийн үед дэлхий нийтийн хандлага эрдэмтэн, судлаачдын мэдлэгийг баялаг болгоход чиглэж байна. Мэдлэгийг баялаг болгоно гэдэг нь эрдэмтдийн эрдэм, шинжилгээний ажил бүтээгдэхүүн болон зах зээлд худалдаалагдаж, эдийн засгийн эргэлтийг үүсгэж байна гэсэн үг. Энэ тал дээр манай сургуулийн удирдлагууд анхаарч, дэргэдээ гарааны компани байгуулсан.

байгаа юм. Энэхүү эмнэлэг маань ашиглалтад орохоор манай резидент эмч нар хүнээ үзээд өөрсдөө тодорхой хэмжээний орлого олоод, цалинжаад явах боломжтой болно. Мөн Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад тасралтгүй хэрэгжүүлж байгаа олон хөтөлбөрийн нэг нь “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр” юм. Одоогийн байдлаар зургаа дахь хөтөлбөр нь хэрэгжиж байгаа байх. Түүний нэг нь дүүргийн жишиг эмнэлэг байгуулах бөгөөд эмнэлэг нь Сонгинохайрхан дүүрэгт баригдана. Бид тус эмнэлэгт ажиллах 12 эмчийг гурван жилийн сургалт бэлтгэж байна. Ингэснээр тухайн эмч нар илүү мэргэшиж, гаршина гэсэн үг. Яах вэ, ганц манай сургууль бэлтгэж байгаа юм биш л дээ. Эрүүл мэндийн хөгжлийн төв ч бэлтгэж байгаа. Бидний гол зорилго бол олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрөөр эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэж өгөх юм. Энэ дагуу хүмүүсээ бэлтгээд явж байна. Мөн олон улсын кибер их сургууль байгуулагдсан. Хөдөө, орон нутагт байгаа эмч, мэргэжилтнүүд ажиллангаа онлайн аар сургалт аваад мэргэжил дээшлүүлэх боломжтой. Үүнтэй холбогдуулан ДЭМБ-ын санхүүжилтээр зайны сургалтын төвийг байгуулж, төрөл бүрийн мөбэйл апплейкэшийг хөгжүүлээ. Манай оюутнууд болон багш, эмч нар онлайн аар тодорхой мэдээлэл авах боломж бүрдсэн. Энэ мэтчилэн бид үргэлж хөтөлбөрийн шинэчлэлийг хийж байна.



/АШУҮИС-ийн Эрдэм, шинжилгээ, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал/

АШУҮИС-ийн гол амин сүнс нь эрдэм, шинжилгээ, хөгжлийн бодлого байдаг. Ялангуяа багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмждэг гэдгээрээ илүү онцлогтой шүү дээ. Энэ тал дээр ямар ажлыг хийж, хэрэгжүүлэв?

Манай сургууль Монгол Улсын хэмжээнд эрүүл мэнд, анагаах ухааны салбарт академик үйл ажиллагаа явуулдаг төв байгууллага. Манай сургууль дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулахаас гадна улсын хэмжээнд анагаахын шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээний



STRESS

Огдын ЦАТ

Милла Йовович:

Маш богино хугацаанд гурав шаардлагатай болсон

Б.ДАВААХҮҮ

Үхдэл хийгээд хүн төрөлхтөний хоорондын ширүүн тэмцэлийн тухай өгүүлэх "Газар доорх ертөнц" киноны анхны цуврал 2003 онд дэлхийн кино театруудын дэлгэцнээ нээлтээ хийж

байв. Тэгвэл түүнээс хойш 14 жилийн дараа тус цувралын сүүлчийн анги үзэгчдэд хүрсэн нь "Газар доорх ертөнц-5" байсан юм. Кино энэ сарын 7-нд Америкийн кино театруудад нээлтээ хийсэн бөгөөд гол дүрд нь Милла Йовович тоглосон

бол найруулагчаар нь түүний ноёр Пол Андерсон ажиллажээ. Мөн тэднийг гол охин нь ч тус кинонд дүр бүтээгээд алжсан байна. Ингээд жүжигчин бүсгүйн уран бүтээлийнхээ талаар дэлгэсэн сонирхолтой ярилцагыг орчуулан хүргэж байна.

-Анхны цуврал гарснаас хойш 14 жилийн дараа сүүлчийн анги нь гарсан. Цуврал ингээд дуусч байна шүү дээ. Таны сэтгэгдэл ер нь ямар байна вэ?

-Ний нуугүй хэлэхэд гунигтай байна. Надтай хамтарч ажиллах хөгжилтэй байдаг гэж хэлдэг атлаа ингээд цувралаа дуусгачихаж байгаад нь нөхөртөө жаахан гомдох шиг. /инээв/

-Алис гэх бүсгүйн дүрийг бүтээснэртаны амьдралд гарсан өөрчлөлт?

-Алисын дүрд тоглосноос хойш би үнэндээ маш олон зүйлийг сурч авсан. Тухайлбал, жүжиглэнэ гэдэг өөрийн болон дүрийнхээ өвөрмөц зан араншинг хамтад нь харуулахын нэр юм байна гэдгийг ойлгосон. Гэхдээ тоглох гэж буй дүрийнхээ онцлог зан чанараас өөртэйгөө нийтлэг талыг нь олж харах хамгийн чухал юм билээ. Тэр утгаар Алисын дүрд тоглосноос хойш дүрийнхээ зан чанарыг гүнзгий таньж мэдэхийг илүүд үзэх болсон.

-Зураг авалт эхлэхийн өмнө

шинэ хүнээ өлгийдөж авсан гэсэн. Үүнийг дагаад зураг авалтын хуваарьт ч өөрчлөлт орсон гэж сонссон юм байна?

-Төрсний дараа биеийн галбирт нэлээд өөрчлөлт орсон. Ер нь хоёр охиноо төрүүлэх үед аль алин дээр нь жин их нэмсэн. Гэхдээ энэ удаагийн цувралын зураг авалт эхлэхээс өмнөхөн нярайлсан учраас маш богино хугацаанд гурав шаардлагатай болсон.

Тэгээд төрмөгчөө л эрчимтэй гурав дасгал хийж, хоолны дэглэм барьж эхэлсэн. Хамгийн хэцүү нь зураг авалтын эхний гурван долоо хоног байлаа. Усан санд өдөрт бараг 10 цагаар үхдэлүүдтэй тулалдах үзэгдлийг авч байсан юм. Эмэгтэй хүний хувьд адал явдалт киноны гол дүрийг бүтээхээс өөр дэглэм барих том шалтгаан бараг байхгүй байв.

-Кинонд том охин тань тоглосон байх аа. Энэ санааг хэн гаргасан бэ?

-Нөхөр маань гаргасан юм. Зураг эхлэхийн яг өмнөхөн л охиноо тоглуулах шийдвэр гаргасан. "Улаан хатан" өөрөө компьютерын систем учраас харагдах байдал нь арай өөр жүжигчин хэрэгтэй

болсон. Бас британи англи хэл, америк англи хэлийг хооронд нь ялгах чадвартай байх шаардлагатай учраас ийм чадвартай хүүхдийг хайсан юм. Азаар Эвер миний авьяасыг өвлөсөн. Түүнийг нь ч аав нь мэддэг учраас энэ дүрд тоглуулахаар сонгосон байх. Охинд маань ч кинонд тоглох таалагдаж байсан шүү. Зураг авалт дууссаны дараа "Ээж ээ, би өөрийн хүсч байсан зүйлээ олчихлоо" гэж хэлж билээ. Үнэхээр урлагт хөл тавих хүсэл эрмэлзлэлээ цаашид хаяхгүй бол охин минь гайхалтай жүжигчин болж чадна гэдэгт би итгэлтэй байгаа.

"Газар доорх ертөнц"-ийн сүүлчийн цувралд гэр бүлээрээ хамтран ажилласан болохоор таны хувьд нэлээд онцгой кино болсон байх нь?

-Миний хувьд дуртай ажлаа хийхээс гадна хайртай хань, охинтойгоо хамтран ажилласан учраас гэр бүлийн минь хамтын бүтээл болж чадсан. Үүнээс өөр аз жаргал гэж хаана байх билээ. Зарим хүмүүс "Гэр бүлээрээ хамтран ажиллах хэцүү биш үү" гэж асууж байсан. Үүндээ огт хэцүү байсангүй.

Улаанбаатарт:

Маргааш
 Өдөр -9
 Шөнө -19

Нөгөөдөр
 Өдөр -13
 Шөнө -23

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.29-17.40
 Үс засуулбал: Өлзийтэй сайн



Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Сүл, сувагаа барих, хүүрийн газар эргэх, чуулан үйлэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чиг хангинавал хэнэртэй учрах, зүүн нь бол идэв ундаа олдох, нохой ушвал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ал болох, тэнэй загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэлцэл болох, хөл татвал сайн болой. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД

Хэзээч Мартахгүй

Өнөөдөр мөсөн дээр хальтраад уначихав. "Ёоо арай ч дээ" гэж бодоод сууж байтал нэг залуу ирээд түшээд босголоо. Би ч "Ямар сайхан сэтгэлтэй залуу вэ" гэж бодоод байрлаж, талархсанаа хэлээд цааш явж байгаад халаасаа үзтэл утас алга. Нөгөөх чинь авчихсан байдаг юм даа. Ёстой л хүндхэн явдал боллоо доо.

ДУУЛГАХ СОНИН



Кисэносато: Энэ зөвхөн эхлэл нь

Сүмогийн холбоо энэ сарын 25-ны түр зөвлөлийн хуралдаанаар Кисэносатод их аварга цол хүртээх гэнэ. Мэргэжлийн сүмогийн 72 дахь их аварга 19 жилийн дараа Японоос төрж буй нь энэ. Барилдааны дараа сэтгүүлчид түүнээс сэтгэгдлийг нь сонсох үед Кисэносато баярын нулимсаа барьж дийлээгүй урсгаж, үүнийгээ "Анх удаа болохоор сэтгэл хөдлөлд" хэмээн ичингүйрэн хариулсан байна. Түүнчлэн, "Хэлэх үг ч олдохгүй байна. Барилдаан хэцүү байсан, гэсэн ч тэсч чадлаа" гэжээ. Түүний барилдааныг үзэгчдийн суудлаас гэр бүлийнхэн нь үзэж байжээ. Харин тэрбээр "Би ганцаараа яагаад ч нийм амжилтад хүрч чадахгүй байсан. Та бүхний дэмжлэг байсан шүү. Дутагдал, сул тал одоо ч надад бий. Цааш цаашдаа илүү хүчтэй барилдааныг үзүүлэх болно. Энэ зөвхөн эхлэл нь" хэмээн нийт дэмжигчиддээ амлажээ.

Японы мэргэжлийн сүмо бөхийн энэ оны эхний хацц башёд озэки Кисэносато 14 даваа, нэг унаатай түрүүлж, Эзэн хааны помьг анх удаагаа хүртлээ. Тэрбээр Макүүчи буюу дээд зиндаанд 13 жил барилдахдаа ганцхан удаа л башёг өнжиж, ямагт Их аваргууд болон озэкицолтнуудад хамгийн халгаатай сүмоч байж ирсэн гэдгээрээ байнга сүмо сонирхогчдын анхаарлын

төвд орж байдаг бөх билээ. Кисэносато 31 башё Оэки цолтой барилдсан амжилтаараа хамгийн урт хугацааны дараа түрүү бөх болж байгаа бөгөөд 15 дахь өдрийн барилдаанд 69 дэх Их аварга Хакухо М.Даваажаргалыг итгэл төгс давж анхны түрүүгээ авлаа. Ингэснээр 1998 онд Ваканоханагаас хойш бүхэн бүтэн 19 жилийн дараа анх удаа Япон бөх ёкозүна цол хүртэх нь нэгэнт тодорхой болов.

"ДОЗ"-ЫНХОН ЭМЭЭ, ОХИН ХОЁРЫГ ГЭРТЭЙ БОЛГОЖЭЭ

"ДОЗ" энтертайнментын захирал Ш.Доржсүрэн, гэргий А.Мөнгөнзулынхаа хамт нэгэн иргэнд хандив өгчээ. Тодруулбал, тэд нэгэн эмээд дулаан, тохилог гэр бэлэглэсэн байна. Бусаддаа үлгэр дуурайлал болж, сайн үйлс бүтээж яваа гэдгийг санаачилгыг өвөрмөц нэвчлэлтэй н.Алтансүх, н.Батхшиг нар дэмжиж, элэг нэгтнүүдээ уриалснаар олны хандив тусламжаар эмээ, охин хоёрыг гэртэй болгосон аж. Харин энэ тухайгаа жүжигчин А.Мөнгөнзул "Хамгийн хүйтэн өдөр хамгийн халуун сэтгэл гаргаж жинхэнэ хүндийг үүрсэн залуусдаа маш их баярлалаа. Найз Алтансүх, түүний гэргий Батхшиг нартаа монголчуудынхаа өмнөөс баярласнаа илэрхийлэе" хэмээн (ФБИС) үг хуудсаараа дамжуулан талархал илэрхийлжээ.



1-Р САРЫН 24-26-НЫ ҮЗВЭРИЙН ХУВААРЬ

 11:15 13:20 15:40 20:20 22:30	 10:30 12:35 16:50 19:00 21:10 23:15	 10:50 12:40 14:35 16:40 18:45 20:50 22:30vip 23:00	 10:35 14:50 17:00	 12:10vip 16:10vip 17:50 20:00 22:10
 12:50 14:50 19:10 23:15	 18:15vip	 14:20vip 20:30vip	 11:00 15:30 21:10	 13:10 17:50